

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА

МОНГОЛ УЛС БА ГЕОПОЛИТИК

А.Амгаланбаяр

ХАУСТ-ийн ахлах багш, цэргийн ухааны магистр, дэд хурандаа

Товч агуулга: Евро Азийн дэлхийд эзлэх байр суурь тэр дундаа өнөө цагт Монгол Улс евроазийн тавцанд геополитикийн хувьд ямар байр суурь эзэлж буй талаар судлахыг зорилоо.

Abstract: We aim to study the position of Eurasia in the world, including the geopolitical position of Mongolia in the Eurasian arena today.

Түлхүүр үг:Евроази, геополитик, геостратеги, бүс нутаг, шатрын хөлөг.

Key words: Eurasia, geopolitics, geostrategy, region, chessboard.

Оршил: Энэхүү илтгэлээр евроазийн дэлхийд эзлэх байр суурь тэр дундаа өнөө цагт Монгол Улс евроазийн тавцанд геополитикийн хувьд ямар байр суурь эзэлж буй талаар судлахыг зорилоо.

Геополитикийн хувьд авч үзвэл евроази нь дэлхий дахинд түүхийн олон үе шатанд элдэв янзын аргаар дэлхийн бүс нутагт ноёрхлоо тогтоож байсны дотор зарим улс орнууд онцгой эрх зүйн байдалтай болж, дэлхийн тэргүүлэх их гүрний байр суурийг эзэлж байлаа.

Еврхоази нь дэлхийд оройлохын төлөө тэмцэл үргэлжлэх шатрын хөлөг бөгөөд тийм тэмцэл геостратегийг зайлшгүй хөндөж байна.

Нэг.Евроазийн геополитик

Дэлхийн тэргүүлэгч гүрнүүдийн гол сонирхол нь Евроази юм. Бүс нутагтаа ноёрхохын төлөө өөр хоорондоо тэмцэхийн хамт дэлхийн хэмжээний эрх мэдэлтэй болохыг оролдож байсан Евразийн улс гүрэн, ард түмнүүд нь дэлхий дахины хэрэг явдалд 500 жил давамгайлж ирсэн билээ.

Евразийн бус нэг улс өнөөдөр тэнд голлох үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд тэрхүү Америкийн глобал оройлол нь Евразийн эх газарт түүний давамгайлах байр суурь хэр үр нөлөөтэй, хэр урт хугацаанд үргэлжлэхээс шууд хамаарна.

Энэхүү болзол түр зуурынх гэдэг нь илэрхий юм. Гэвч, түүний үргэлжлэх хугацаа болон араас нь залган гарах зүйлс нь зөвхөн Америкийн сайн сайхны хувьд


төдийгүй бүхэлдээ дэлхий дахины энхийн үйлсэд онцгой холбогдолтой юм.

Харвардын их сургуулийн улс төр судлаач Сэмүэл Ф.Хантингтоны дараах зоримог үг үнэндээ зөв юм: "Глобал асуудлыг шийдэхэд АНУ бусад ямар ч орноос илүү нөлөөлсөөр байгаа аливаа газрыг бодвол, АНУ-ын оройлол байхгүй байх газарт эмх замбараагүй байдал, хүчирхийлэл их, ардчилал, эдийн засгийн өсөлт бага байх болно. АНУ-ын олон улсын хэмжээний байнгын оройлол нь америкчуудын аюулгүй байдал, сайн сайхны хувьд болон эрх чөлөө, ардчилал, нээлттэй эдийн засгийн ирээдүйн хувьд мөн дэлхий дахины олон улсын дэг журамд хамгийн чухал зүйл даруй мөн" Үүнтэй уялдан, Америк Евразийг хэрхэн "удирдаж" байна вэ гэдэг нь амин чухал асуудал юм. Еврази нь дэлхийн хамгийн том тив бөгөөд геополитикийн үүднээс гол тэнхлэгийн байршлыг эзэлдэг.



Евразид ноёрхож буй улс нь дэлхийн хамгийн хөгжилтэй, эдийн засгийн хамгийн үр ашигтай гурван бүс нутгийн хоёрыг нь хянаж байна гэсэн үг. Дэлхийн газрын зургийг зэрвэсхэн харахад л Евразид ноёрхсоноор Африкийг бараг аяндаа эрхшээлдээ оруулж, далайн орнууд болон дэлхийн баруун хэсгийг төвлөгч тивийн ар хударгын хязгаар болгон хувиргана гэж таамаглаж болохоор юм. Манай гаргийн нийт хүн амын 75 хувь нь Евразид нутагладаг бөгөөд дэлхийн биет баялгийн ихэнх хэсэг нь тэндхийн хөрсөн дор буюу үйлдвэрлэл дээр байгаа билээ.

Дэлхийн ҮНБ-ний 60 орчим хувь, дэлхийн эрчим хүчний илэрсэн нөөцийн 34 орчим хувь нь Евразид ноогдож байна.



Түүнчлэн, Евразид улс төрийн хувьд дэлхийн хамгийн идэвхтэй, эрчимтэй улсууд оршдог. АНУ-ын дараа орох зургаан том эдийн засаг, зэвсэглэлд хамгийн их зардал гаргадаг зургаан том улс Евразид байна. Ил цөмийн зэвсэгтэй улсуудын ганцаас бусад нь, мөн далд цөмийн зэвсэгтэй улсуудын ганцаас бусад нь бүгд Евразид оршдог.

Бүс нутгийн ноёрхол болон дэлхийн хэмжээний нөлөөний төлөө өрсөлддөг хамгийн их хүн амтай хоёр улс мөн тэнд оршдог. Америкийн оройллыг улс төр, эдийн засгаар буюу тэдгээрийн аль нэгээр сорих бодит дуудлага Евразиас л гардаг. Бүхэлдээ Евразийн нэгдсэн хүч чадал америкийнхыг илт давж байгаа юм.

Еврази нь улс төрийн хувьд нэгдмэл байхын аргагүй дэндүү том орон зай билээ. Ийнхүү, Еврази нь глобал ноёрхлын төлөө тэмцэл үргэлжилж байгаа шатрын хөлөг болж байна. Хэдийгээр геостратегийг (геополитикийн ашиг сонирхлын стратегийн удирдлага) шатартай зүйрлэж болох ч Евразийн зуувандуу шатрын хөлөг дээр хоёр биш харин дор бүрдээ янз бүрийн зиндааны эрх мэдэл бүхий хэд хэдэн тоглогч тоглож байна. Тэргүүлэх тоглогчид нь шатрын хөлгийн баруун, зүүн, төв, өмнөд хэсэгт оршиж байна.

Шатрын хөлгийн баруун, зүүн хэсгийн аль алинд нь хүн ам шигүү суурьшсан бүс нутгууд байгаа

бөгөөд тэдгээр нь хүн ам харьцангуй хэт олширсон орон зайд хэд хэдэн хүчирхэг улсыг үүсгэдэг болно.

Евразийн байрласан олон хүн амыг хянахын зэрэгцээ улам бүр багашаархан баруун хязгаарт бол Америкийн хүч шууд дээр нь хүчирхэгжин биеэ дааж байгаа тоглогчийн оршдог газар нь Алс Дорнод юм.

Гэхдээ түүний ойролцоох хэдэн арал дээр хашигдсан эрчимтэй өрсөлдөгчийнх нь газар нутаг, түүнчлэн Алс Дорнодын жижгэвтэр хойгийн тэн хагас л Америкийн ноёрхол нэвтрэн орох зам болж байна. Баруун, зүүн үзүүрийн хоорондох хүн ам сийрэгхэн газар нутаг нь одоогоор улс төрийн хувьд тогтворгүй, зохион байгуулалтын хувьд хуваагдмал байгаа юм.

Төв Евразийн энэ том тэгш өндөрлөгийн өмнөд хэсэгт улс төрийн хувьд эмх замбараагүй, гэхдээ эрчим хүчний баян нөөц бүхий бүс нутаг байна. Энэ бүс нутаг бол урд биеэрээ бүс нутгийн жанжлагч болохыг горилдог, шигүү хүн амтай нэгэн улс бүхий энэ бүс нутаг бол орнод, дорнодын улсуудын аль алинд нь цаагуураа чухал ач холбогдолтой.

Энэхүү евразийн аварга том шатрын хөлөг дээр "тоглоом"-д оролцох шатрын хүү боднууд байрлаж байна. Хэрвээ дунд хэсгийг өргөжиж буй өрнөдийн (энд Америк давамгайлж байгаа) эргүүлэгт оруулж болбол, хэрвээ өмнөд бүс

нутагт нэг тоглогчийн ноёрхол тогтохгүй бол, хэрвээ дорно хэсгийн тоглогч нар нэгдэж Америк далайн баазаасаа явахаас өөр аргагүй болохгүй бол Америкийг сая яллаа гэж хэлж болох юм.

Хэрвээ дорнод хэсгийн хоёр том тоглогч хоорондоо ямар нэг хэлбэрээр нэгдвэл мөн яг тийм хэрэг болно. Эцэст нь, өрнөдийн холбоотнууд нь Америкийг баруун хязгаар дахь үүрнээс хүчээ авсан тоглогчийн эрхшээлд оруулах магадлалтай байлаа ч зайлуулбал тэр нь эцсийн дүндээ баруун хязгаарыг дунд хэсэгт гэсэн Америкийн хувьд бол Евразийн шатрын хөлөг дээрх тоглоомд оролцох явдал дуусгавар боллоо гэсэн үг.

Саяхныг хүртэл геополитикийн салбарын тэргүүлэх шинжээчид хуурай газарт ноёрхох нь тэнгист ноёрхсоноос илүү ач холбогдолтой юу, Евразийг бүхэлд нь хянахад аль бус нутаг нь амин чухал ач холбогдолтой вэ зэрэг асуудлаар мэтгэлцэж байлаа. Гарамгай геополитикчдын нэг болох Харолд МакКиндэр энэ зууны эхэнд нэгэн хэлэлцүүлгийг санаачилсан бөгөөд уг хэлэлцүүлгийн дараа түүний Евразийн “тулгуур газар нутаг” (тэр дэвсгэр нутагт бүх Сибирь, Дундад Азийн ихэнх хэсгийг оруулах ёстой гэж үзсэн байв) гэдэг номлол гарсан бөгөөд сүүлд нь, Евразид давамгайлахад чухал тушиц газар гэдгээр Төв болон Дорнод Европын “зүрх” хэмээх

номлолоо зохиосон юм. Тэрээр энэхүү “газрын зүрх”-ний тухай номлолоо доорх мэргэн үгээр хялбаршуулан дэлгэрүүлсэн юм:

Хэн Дорнод Европыг захирна, тэр Газрын зүрхийг удирдана;

Хэн Газрын зүрхийг захирна, тэр Дэлхийн арлыг удирдана;

Хэн Дэлхийн арлыг захирна, тэр дэлхийг удирдана.

Өнөөгийн дэлхий дахины геостратегийн таван үндсэн тоглогч мөн тийм тооны геополитикийнтөвийг (үүний хамтад сүүлийн хоёр нь зарим талаар тоглогчийн ангилалд давхар орж магадгүй) Евразийн улс төрийн шинэ зурган дээр гаргаж тавьж болох юм. Франц, Япон, Индонез нь (нийтээр хүлээн зөвшөөрснөөр маш чухал улсууд) энэ ангилалд орохгүй байна.

Украин, Азербайжан, Өмнөд Солонгос, Турк, Иран нь зарчмын хувьд чухал геополитикийн төвүүдийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд Турк, Иран нь ямар нэг хэмжээгээр (өөрсдийнхөө хязгаарлагдмал бололцооны хүрээнд) бас геостратегийн идэвхтэй орнууд юм. Дараа дараагийн бүлэгт эдгээр улсын тухай тус бүрд нь тодорхой өгүүлнэ. Евразийн баруун дүүрэгт Франц, Герман хоёр геостратегийн эрч хүчтэй үндсэн тоглогчид болж байгааг энэ шатанд хэлэхэд хангалттай юм.

Евразийн шатрын хөлөг дээрх шинэ, чухал орон зай болж

буй Украин бол тусгаар улс болон оршин тогтнож байгаагаараа Оросыг хувьсган өөрчлөхөд нэмэртэй учраас геополитикийн төв юм. Тийм ч учраас 2022 оны 02 дугаар сараас эхлэн Оросын Холбооны Улсаас Украин улсад цэргийн тусгай ажиллагаа өдийг хүртэл явуулж байна.

Хоёр.Монголын геополитик евроазид эзлэх байр суурь

Монгол Улсын геополитик евроазид эзлэх байр суурийг дурдахын тулд Монголын эзэнт гүрнийг авч үзэх ёстой байна. Энэхүү эзэнт улс хүчтэй, сайн зохион байгуулалттай өрсөлдөгчтэй хийсэн ширүүн тэмцлийн үр дүнд бий болсон юм.

Ялагдагсдын дунд Польш, Унгарын хаант улс, Ариун Ромын эзэнт улсын хүчнүүд болон Оросын хэд хэдэн ханлигууд, Багдадын халифат, тэр ч байтугай хожим хятадын Сун улс ч орж байв.

Чингис хаан болон түүний үе залгамжлагчид бүс нутгийнхаа өрсөлдөгчдийг байлдан дагуулсаар өнөөдрийн геополитик судлаачид бөмбөрцгийн голт зүрх буюу дэлхийд ноёрхол тогтоох тулгуур цэг хэмээн тодорхойлдог газар нутагт төвлөрсөн хяналт тогтоож байсан бөгөөд Хятадын тэнгисийн эргээс Бага Ази дахь Анатоли болон Төв Европ хүртэлх өргөн уудам нутгийг эзэгнэж байлаа.


Монголын эзэнт гүрний байдал үүний эсрэг буюу улс төрийн

тогтвортой хяналтын гол нь цэргийн түрэмгийлэлдээ түшиглэж байснаас гадна өөрсдөө тухайн газар орныхоо нөхцөлд дасан идээшиж, (тэр ч бүү хэл, бүр уусан нэгддэг) байв.

Хүчээ маш хурдан шилжүүлэн байршуулах, шаардлагатай үед нэгтгэн төвлөрүүлэх гайхамшигт боломжийг агуулсан хатуу дэгтэй гялалзсан сайн тактикийг хэрэглэсний үр дүнд бүрдсэн Монголын ноёрхлыг эдийн засгийн буюу санхүүгийн зохион байгуулалттай тогтолцоо дагаж гарч ирээгүйгээс гадна монголчуудын эрх мэдэл соёлоор давамгайлах үзэл сэтгэлд тулгуурлаагүй юм. Монголын эрх баригчид эрхшээлдээ оруулсан, соёлын хувьд ихэнхдээ илүү хөгжсөн ард түмнүүдтэй алгуур ижилсэн уусахдаа нэлээд амархан байсан юм.

Жишээлбэл, Эзэнт улсын Хятад дахь хэсгийг эзэрхэж байсан Чингис хааны нэг ач Күнзийн сургаалыг улайран дэлгэрүүлэгч байсан; өөр нэг нь Персийн султан болоод үнэнч шударга лалын сүсэгтэн болсон; гурав дахь нь соёлын талаас нь авч үзвэл Төв Азийн перс захирагч болжээ.

Монголын эзэнт улс ганц төвөөс удирдах дэндүү том болсон, гэтэл уг асуудлыг эзэнт гүрнээ хэд хэдэн бие даасан хэсэгт хуваах



замаар шийдэх гэж оролдсоор бусдад уусах үйл явц улам хурдсаж эзэнт улсын задралыг түргэсгэсэн гэж үзжээ.

Одоо цагт Москва 52 сая хүн амтай, ихээхэн нөөц баялагтай, цаашилбал Хар далайн гарцтай Украиныг буцааж хяналтдаа оруулбал Европ, Азийг эзэгнэсэн хүчирхэг эзэнт улс болж хувирах хэрэгслийг дахиад олж авна гэсэн үг.

Украин тусгаар тогтнолоо алдвал Төв Европт тэр даруй үр дагавар нь тусаж нэгдсэн Европын дорнод хязгаарт Польшийг геополитикийн төв болгон хувиргана. Азербайжан нь газар нутгийн хэмжээгээр бага, хун амын геополитикийн тэргүүлэх ач холбогдолтой улс. Энэ бол Каспийн тоогоор их биш ч гэсэн эрчим хүчний асар их нөөцтэй учраас тэнгисийн сав газар болон Дундад Азийн баялгийг агуулсан савны бөглөө юм.

Хэрвээ Азербайжан Москвагийн эрхшээлд бүрмөсөн Орчихвол Дундад Азийн улсуудын тусгаар тогтнолыг хэрэг дээрээ устгасан тохиолдолд Азербайжаны газрын тосны их нөөц тэрчлэн учир утгагүй ойлголт гэж үзэж болно. Энэ орны тусгаар тогтнолыг Оросын мэдэлд орж болно. Оросын хянаж буй нутаг дэвсгэрээс гадуур татсан, өрнөдийн зах зээлтэй холбогдсон газрын тосны дамжуулах хоолойтой, тусгаар тогтносон Азербайжан нь өрнөдийн эрчим хүч хэрэглэдэг тэргүүний эдийн засаг, Дундад

Азийн эрчим хүчний баялаг нөөцтэй Дундад Азид хүрэх чухал төв зам бас болно.

Ирээдүйн Азербайжан, Дундад Ази нь Орос хэн болох эсэхээс яг Украин шиг зарчмын хувьд нэгэн адил хамаарна. Турк, Иран хоёр Каспийн болон Дундад Азийн бүс нутагт Оросын хяналт алдагдсаныг далимдуулж тэнд тодорхой хэмжээгээр нөлөөгөө тогтоохыг оролдоцгоож байна. Энэ үүднээс тэднийг геостратегийн тоглогчид гэж тооцож болмоор. Гэвч хоёулаа дотооддоо ноцтой асуудлуудтай байдгаас болоод бүс нутгийн хүчний хуваарилалт мэдэгдэхүйц өөрчлөлт оруулах боломж хязгаарлагдмал.

Түүнээс гадна, тэр хоёр улс хоорондоо өрсөлдөгчид, тийнхүү бие биеийнхээ нөлөөг үгүй хийдэг. Жишээлбэл, Турк Азербайжанд ихээхэн нөлөө тогтоосноор Ираны байр суурь (оорийнх нь нутгийн азербайжанчууд үндсэрхэх хөдөлгөөн гаргаж болзошгүйгээс болгоомжилсон байр суурь) Оросын хувьд илүү ашигтай болов.

Гэхдээ Турк, Ираны аль аль нь юуны өмнө геополитикийн чухал төв юм. Турк Хар далайн бүс нутгийг



тогтворжуулдаг, эндээс Газар дундын тэнгист хүрэх гарцыг хянадаг, Кавказад Оросыг тэнцвэржүүлдэг, түүнчлэн лалын фундаментализмын ерондог хэвээр байгаагийн зэрэгцээ НАТО-ийн өмнөд зангууны үүргийг гүйцэтгэдэг.

Турк тогтворгүй болбол Өмнөд Балканд хүчирхийллийг улам чөлөөтэй болгохын зэрэгцээ саяхан тусгаар тогтнолоо олсон Кавказын улсуудад Оросын нөлөө дахин сэргэхэд хүргэнэ.

Иран Азербайжантай хоёрдмол янзаар харилцаж байгаа хэдий ч Дундад Азид шинээр бий болсон улс төрийн эрээвэр тогтолцоог тогтворжуулахад дээрхтэй төстэй дэмжлэг үзүүлж байна.

Иран Персийн булангийн зүүн эрэгт давамгайлдаг бөгөөд хэдийгээр өнөөдөр АНУ-тай дайсагналцаж байгаа ч түүний тусгаар тогтнол нь энэ бүс нутаг дахь Америкийн сонирхолд Оросын зүгээс хэтдээ учруулж болох аливаа аюул заналд хаалт болж байгаа юм.

Эцэст нь дурдахад, Өмнөд Солонгос бол Алс Дорнодын геополитикийн төв юм. Түүний АНУ-тай тогтоосон хэлхээ холбоо нь Америкийг Японы хувьд бамбайн үүрэг гүйцэтгэх боломжийг олгож, тэгснээрээ Японыг Америкийн голлох оролцоогүйгээр бие даасан, хүчтэй цэргийн гүрэн болж хувирах боломжийг нь хааж байна.

Тоглогчид геополитикийн дурдсан геостратегийн Дээр

төвүүдийн жагсаалт нь нэгэнт тогтоочихсон өөрчлөгдөшгүй зүйлс би юм. Цаг хугацааны явцад зарим улс уг жагсаалтад шинээр орох буюу зарим нь хасагдаж болно.

Тайвань эсвэл Тайланд, Пакистан, эсвэл магадгүй Казахстан, Узбекистан зэрэг улсыг геополитикийн төвийн ангилалд оруулах хэрэгтэй байсан байж болох нь эргэлзээгүй. Эдгээрийн алины нь ч статусын өөрчлөлт хэрдээ томоохон үйл явдал болж, түүнийг дагаад хүчний хуваарьт ч зарим өөрчлөлт гарах боловч үр дагавар нь тэгтлээ алсын тусгалтай байх нь эргэлзээтэй юм.

Энэхүү нөхцөл байдалд Монгол Улс нь эдийн засаг, нийгэм, улс төрийн хүчин зүйлээс шалтгаалан евроазийн геополитикийн тоглогч болох нөхцөл бүрдээгүй гэж үзэж байна. Цаашид тоглоомын тоглогчид нь Монгол Улсын байгалийн баялаг, евроазийг холбосон худалдааны богино эргэлтийн зам, газар зүйн байрлал стратегийн түшиц газрын үүднээс дэлхийн томоохон тоглогчдын сонирхлыг татсаар ирсэн. Гэвч дэлхийн томоохон эдийн засаг үндсэн тоглогчдын нэг болох АНУ манай улсад өөрсдийн бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг явуулах, эрх мэдлийг тогтооход хөрш хоёр улсын нөлөөлөл саад болж байна.

Цаашид дээр дурдсан түшиц газарт геостратегийн тоглогчдын ашиг сонирхлыг хэрэгжүүлэх, хөрш улсуудад нөлөө үзүүлэх, тэдгээрийн

хүчийг сулруулах бодлогыг өрнүүлэх талаар томоохон тоглогчид Монгол Улсыг тоглоомын хүү байлгах үзэл суртал хүчтэй хэрэгжих болно.

Дүгнэлт: Монгол Улс нь эдийн засаг, нийгэм, улс төрийн хүчин зүйлээс шалтгаалан евроазийн геополитикийн тоглогч болох нөхцөл бүрдээгүй гэж үзэж байна. Цаашид тоглоомын тоглогчид нь Монгол Улсын байгалийн баялаг, евроазийг холбосон худалдааны богино эргэлтийн зам, газар зүйн байрлал стратегийн түшиц газрын үүднээс дэлхийн томоохон тоглогчдын сонирхлыг татсаар ирсэн. Гэвч дэлхийн томоохон эдийн засаг үндсэн тоглогчдын нэг болох АНУ манай улсад өөрсдийн бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг явуулах, эрх мэдлийг тогтооход хөрш хоёр улсын нөлөөлөл саад болж байна.

Цаашид дээр дурдсан түшиц газарт геостратегийн тоглогчдын ашиг сонирхлыг хэрэгжүүлэх, хөрш улсуудад нөлөө үзүүлэх, тэдгээрийн хүчийг сулруулах бодлогыг өрнүүлэх талаар томоохон тоглогчид Монгол Улсыг тоглоомын хүү байлгах үзэл суртал хүчтэй хэрэгжих болно гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Mackinder Н. "The Round World and the Winning of the Peace."
- Галиймаа Н. XX зууны Монгол, Америкийн харилцаа: үүсэл хөгжил, тулгамдаж байсан асуудлууд. УБ.2001
- Mineral Resources and Petroleum Authority of Mongolia, March 2008
- <http://www.worldbank.org/mn/news>
- www.mram.gov.mn